



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/131

Чингис хот

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалт, халдваргүйтгэл, лабораторийн  
шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 9 дүгээр зүйлийн 9.1-9.9, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.5 дахь заалт, Засгийн газрын 225 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт байгаа мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж дархлаажуулах, мал, амьтны хашаа байр, мал төхөөрөх үйлдвэрийн орчин талбай, худаг уст цэг, түүхий эд бүтээгдэхүүн, тэжээлийн агуулах, малын бэлчээрийг халдваргүйтгэх, лабораторийн оношлон, тандах шинжилгээ хийх ажлыг 2021 оны 3 дугаар сарын 10-аас 2021 оны 11 дүгээр сарын 10-ыг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, халдваргүйтгэл, тандалт шинжилгээний ажилд шаардагдах био бэлдмэл, эмийн бодис, урвалж, хэрэгсэл, мэргэжлийн удирдлага, заавар арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т, сум орон нутагтаа графикт хугацаанд нь шуурхай зохион байгуулж малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулах, тээврийн хэрэгсэл, хүн хүчээр хангах ажлыг сумдын Засаг дарга нарт тус тус хариуцуулсугай.

3. Мэргэжлийн байгууллагаас тогтоосон хугацаанд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн малчин, мал бүхий иргэд, холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож, ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т үүрэг болгосугай.

4. Мал эмнэлгийн арга хэмжээний явц, гүйцэтгэлд хяналт тавьж, дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ

231010364